



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/163

Мандалговь

Аймгийн хурдан морины бүсийн уралдааны  
2019 оны хуваарийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 (а), 29.1.6 (г) заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн “Нарны хүлэг” морин спорт уяачдын холбооны болон сумдын Засаг дарга нарын саналыг үндэслэн 2019 онд зохион байгуулах аймгийн хурдан морины бүсийн уралдааны хуваарийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Хурдан морины уралдааныг холбогдох хууль тогтоомж болон “Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавигдах шаардлага” MNS6264:2018 стандартыг бүрэн хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг сумдын Засаг дарга, “Нарны хүлэг” уяачдын холбоо (Ц.Ганхүү)-нд тус тус даалгасугай.

Гурав. Хурдан морины уралдааны явцад байнгын хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Ц.Ганзориг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190448

Аймгийн Засаг даргын 2019 оны  
 4 дүгээр сарын 23-ны  
 өдрийн А/163 дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ХУРДАН МОРИНЫ БҮСИЙН УРАЛДААНЫ  
 2019 ОНЫ ХУВААРЬ

№	Уралдааны нэр	Уралдаан зохион байгуулагдах газар	Уралдах нас	Хугацаа
1	"Мандлын хурд-2019" төвийн бүсийн уралдаан /МУ-ын Манлай уяач Б.Лхагва-Очир, МУ-ын Алдарт уяач С.Мөнхбатын нэрэмжит/	Хулд сум	а/ Их нас б/ Соёолон в/ Хязаалан	2019.05.18
2	"Дэлгэрхангай уулын тахилга" баруун бүсийн хурдан морины уралдаан	Дэлгэрхангай сум	а/ Их нас б/ Соёолон в/ Даага	2019.05.13
3	Их Угтаал уулын тахилга наадам	Говь-Угтаал сум	а/ Азарга б/ Их нас в/ Соёолон	2019.05.12
4	Луус "Дайчин бэйсийн хурд-15" Цагаан-овооны уулын тахилга наадам	Луус сум	а/ Их нас	2019.06.02
5	Баруун бүсийн хурдан морины уралдаан	Сайхан-Овоо сум	а/ Азарга б/ Хязаалан в/ Шүдлэн	2019.06.22
6	Зүүн бүсийн хурдан морины уралдаан /Доод 3 нас/	Дэрэн сум	а/ Хязаалан б/ Шүдлэн в/ Даага г/ Эрлийз бага	2019.07.09
7	Өмнөд бүсийн хурдан морины уралдаан /Дээд 3 нас/	Өндөршил сум	а/ Азарга б/ Их нас в/ Соёолон г/ Эрлийз дунд	2019.07.15-16
8	Адаацаг сумын 60 жилийн ойн баяр наадамд зориулсан хойд бүсийн хурдан морины уралдаан	Адаацаг сум	а/ Азарга б/ Их нас в/ Соёолон г/ Хязаалан д/ Шүдлэн г/ Даага	2019.07.27-28